



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/21


Чингис хот

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах ажлыг хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах журмын 5.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр ханган ажиллахыг Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицерт хавсран гүйцэтгүүлсүгэй.
2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ж.Гантулга/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР